263

БНМАУ

# УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1990 оны 5 дугаар сарын 29-ний өдөр

дугаар 99

Улаанбаатар хот

90 314

Ашиглалтын өмнөх захиргаа байгуулах тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 21 дүгээр протоколыг үндэслэн Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1.Төмөр замын 18 дугаар зөрлөгт байрлаж байсан Зөвлөлтийн цэргийн хотхон /Лүн/-ны барилга байгууламжид үйлдвэрлэл, үйлчилгээ /гадаадын байгууллагатай хамтран ажиллах хэлбэрийг оролцуулан/ зохион байгуулах ашиглалтын өмнөх захиргааг 1990 оны 5 дугаар сарын 25-наас байгуулан ажиллуулахаар тогтоосугай.

2.Зөвлөлтийн талаас "Лүн хотхоныг" хүлээж авах комиссын бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, ашиглалтын өмнөх түр захиргааны зардлыг 2 дугаар хавсралтын ёсоор баталсугай.

3.Лүн хотхонд сургууль, цэцэрлэг, ясли, эмнэлэг зохион байгуулж ажиллуулах, худалдаа нийтийн хоол, холбооны болон соёл ахуйн бусад үйлчилгээг бий болгох санал тооцоог энэ оны 6 дугаар сард багтаан боловсруулж оруулахыг комиссын дарга Ц.Баасанжав болон ашиглалтын өмнөх захиргаанд даалгасугай.

4.Нийгэм эдийн засгийн хөгжлийн улсын хороонд байгуулагдсан зөвлөлтийн цэргийн хотхонууд тэдгээрийн барилга байгууламжийг иж бүрнээр ашиглах арга хэмжээг зохион байгуулах,ашиглалт хамгаалалтад хяналт тавьж зохицуулах үүрэг бүхий ажлын хэсэгтэй байнгын холбоотой ажиллахыг комиссын дарга Ц.Баасанжавт даалгасугай.

5.Ашиглалтын өмнөх түр захиргааны зардлыг хотын 1990 оны төсвийн хийдэгдлээс гаргахыг санхүүгийн хэлтэс /н.Гонгор/-т зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА Л.ЭНЭБИШ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Д.АЛТАЙ

БНМАУ Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1990 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн 99 дугаар тогтоолын хавсралт.№ I.

## "ЛҮН" ХОТХОНЫГ ХҮЛЭЭЖ АВАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

| | | |
|---|---|---|
| Комиссын даргад: | Ц.Баасанжав | - Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны орлогч дарга |
| Нарийн бичгийн даргад: | Л.Дашжаргал | - ЗХЖШ-ын ахлах офицер |
| Гишүүдэд: | Х.Болдхуяг | - НЭЗХУ хорооны ажилтан |
| | С.Батмагнай | - Ардын боловсролын удирдах газрын дарга |
| | Б.Пүрэвхүү | - ОСНААУ газрын орлогч дарга |
| | Ж.Жуваа | - АҮУГ-ын дарга |
| | Б.Бизъяа | - Соёлын хэлтсийн дарга |
| | П.Бямбаа | - Эрүүлийг хамгаалах газрын дарга |
| | Д.Гарамжил | - Галдан сэргийлэх газрын орлогч дарга |
| | С.Аюурсэд | - Дулааны шугам сүлжээний газрын дарга |
| | Ц.Хатанбаатар | - Цахилгаан шугам сүлжээний газрын дарга |
| | А.Резабек | - Телефон радио ашиглалтын хорооны ерөнхий инженер |
| | Б.Ганбаатар | - Хүнсний бараа худалдааны нэгдлийн орлогч дарга |
| | Д.Мижиддорж | - АҮБХН-ийн дарга |
| | Г.Вандандорж | - Нийтийн хоолны удирдах газрын дарга |
| | Д.Гонгор | - Хотын санхүүгийн хэлтсийн дарга |
| | С.Баатарсүрэн | - Хотын гүйцэтгэх захиргааны зохион зааварлах хэлтсийн тасгийн дарга |
| | Д.Пүрэвжав | - БХЯ-ны БЗ товчооны дарга |

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1990 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн 99 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт.

# "ЛҮН" ХОТХОНЫ АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ТҮР ЗАХИРГААНЫ ОРОН ТОО, ЗАРДАЛ, АЛБАН ТУШААЛ, ЦАЛИНГИЙН САН

| Албан тушаал | тоо | сарын цалин |
|---|---|---|
| I.Ашиглалтын өмнөх захиргааны дарга-хорооны дарга | I | II00 |
| 2.Хорооны нарийн бичгийн дарга | I | 800 |
| 3.Орон сууц, нийтийн аж ахуй, шугам сүлжээний группийн дарга | I | 800 |
| 4.Орон сууц, нийтийн аж ахуй, шугам сүлжээний асуудал хариуцсан мэргэжилтэн | I0 | 7000 |
| 5.Цагдан сэргийлэх группийн дарга | I | 700 |
| 6.Сэргийлэгч, автын байцаагч | 4 | 2700 |
| 7.Бүртгэл тайлан, төлөвлөлтийн группийн дарга | I | 750 |
| 8.Төсвийн мэргэжилтэн | I | 700 |
| 9.Ня-бо | 2 | I200 |
| I0.Архив-бичээч | I | 400 |
| II.Жолооч | 6 | 2700 |
| I2.Сахиул | 20 | 6000 |
| I3.Худалдаа, нийтийн хоол хариуцсан мэргэжилтэн | I | 700 |
| I4.Дулааны аж ахуйн дарга | I | 750 |
| I5.Авто гражийн дарга, механикч | I | 700 |
| I6.Албан томилолтын зардал | - | I0000 |
| I7.Машины шатахууны зардал | | 20000 |
| I8.Бусад /тээвэр, түлш, цэвэрлэгээ, хамгаалалт, засвар тохижилт зардал/ | | I00000 |
| Цалингийн сан | | I73490 |
| ДҮН | 52 | 303490 |

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА